



БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/403

Улаанбаатар хот

Г Мал, тэжээвэр амьтдын тооллого
явуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 222 дугаар тогтоол, 2015 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний А/909 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтдын 2017 оны тооллогыг 12 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд, хяналтын тооллогыг 12 дугаар сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд тус тус явуулсугай.

2. Тооллогын бэлтгэл ажлыг хангуулах, зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар, комиссын гишүүдийн хороодод ажиллах хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Дүүргийн мал тэжээвэр амьтдын тооллогын ажилтны сургалт, тооллогын бэлтгэлийг хангах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэх зэрэг зохион байгуулалтын зардалд 3,737,300 /гурван сая долоон зуун гучин долоон мянга гурван зуу/ төгрөгийг Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газар /Б.Амартувшин/-т зөвшөөрсүгэй.

4. Туршлагатай иргэд, идэвхтэн сонгуультнаас бүрдсэн салбар комиссыг байгуулж, тооллогыг тогтоосон хугацаанд удирдамж, зааврын дагуу явуулан, дүн мэдээ, материалыг дүүргийн Статистикийн хэлтэст ирүүлэхийг хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Дүүргийн мал, тэжээвэр амьтдын тооллогын явцын мэдээ болон нэгдсэн дүнг Нийслэлийн Статистикийн газарт хугацаанд нь хүргүүлж, тооллогын дүнг боловсруулан 2018 оны 1 дүгээр сард багтаан тархаан, уг захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн удирдагч-Засаг даргын орлогч Д.Уламбаярт, дүүргийн Статистикийн хэлтсийн дарга Э.Энхтунгалаг нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ